



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2013 оны 08 дугаар сарын 01-ний өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Монголбанкны Гачуурт дахь зуслангийн байрнуудад засварын ажил хийж гүйцэтгэх

Тендер шалгаруулалтын дугаар: GZ-2013/02

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчоос засварын ажил хийж гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендер нь 1 багцтай байна.

Тендерийн бичиг баримтыг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 100,000.00 (нэг зуун мянган) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд тушаана. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 150,000,000.00 (нэг зуун тавин сая) төгрөг,

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 150,000,000.00 (нэг зуун тавин сая) төгрөг,

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх он: 2012 он.

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 2 (хоёр) хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.

Тендерийг 2013 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2013 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 10 цаг 30 минутанд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийн доорх хаягаар авч болно.

**Монголбанк,  
Бага тойруу -3, 15160, Улаанбаатар хот,  
Монголбанкны “А” байрны 1 давхар, 2 тоот өрөө**

**Утас: (976) 11-310633, 327048, Факс: (976) 11-311471**